**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ДАА-2026/91/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.Shinjlenmagadlahui<br>ezshaudit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр<br>Утас: 70373089, 99023682<br>Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn<br>Аудитын менежер: У.Батсүрэн<br>Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn<br>Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК<br>Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui. audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 140

танай ______________-ны №________________ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН
32 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.БАЯРЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Хонгор сумын 32 дугаар цэцэрлэгийн 2025 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 75.8 хувийг цалин хөлс, 18.5 хувийг нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал, бараа үйлчилгээний бусад зардал, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал, 5.7 хувийг урсгал засварын зардал тус тус эзэлж байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4526050226

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр тус цэцэрлэгийн цалингийн зардал 183,382.0 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 10.0 хувиар өссөн байна.

**Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэг нь байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 49 арга хэмжээний хүрээнд ажлаа төлөвлөж , 47 ажил нь 95 хувь 2 ажил нь 85 хувийн биелэлттэй ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ бүлэгт эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР** **Ш.МӨНХБАЯР**

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**СТ-1А**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** /Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **88,224,936.64** | **88,224,936.64** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 40,117,657.60 | 15,176,469.62 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | - | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 40,117,657.60 | 15,176,469.92 |
| 3121 | Төгрөг | 40,117,657.60 | 15,176,469.62 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 40,117,657.60 | 15,176,469.62 |
| 314 | Замд яваа мөнгөн хөрөнгө | - | - |
| 33 | АВЛАГА | 1,112,398.74 | 1,112,398.74 |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,112,398.74 | 1,112,398.74 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **46,994,880.30** | **61,378,008.40** |
| 354 | Хангамжийн материал | 46,994,880.30 | 61,378,008.40 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 233,000.00 | 233,000.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 13,211,000.30 | 22,525,700.30 |
| 3546 | Хүнсний материал | 2,124,980.00 | 560,089.10 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 31,425,900.00 | 38,059.219.00 |
| II | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,930,777,936.71** | **2,900,153,040.14** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,930,777,936.71 | 2,900,153,040.14 |
| 392 | Биет хөрөнгө | 2,928,373,770.04 | 2,898,798,873.47 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,871,210,303.00 | 2,871,210,303.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (31,902,336.72) | (79,755,841.80) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 70,898,103.84 | 101,365,433.24 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (7,688,645.66) | (26,124,705.83) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 25,063,603.00 | 28,133,093.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (2,725,437.42) | (9,001,348.79) |
| 39209 | Зам, гүүрний байгууламж | | 5,000,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | | (20,833.33) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,781,000.00 | 8,756,023.98 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (42,500.00) | (763,250.00) |
| 39217 | Ном | 779,680.00 | 0.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 2,404,166.67 | 1,354,166.67 |
| 39301 | Програм хангамж | 3,150,000.00 | 3,150,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (745,833.33) | (1,795,833.33) |
| III | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,019,002,873.35** | **2,977,819,916.90** |
| V | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,019,002,873.35** | **2,977,819,916.90** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,019,002,873.35 | 2,977,819,916.90 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 3,019,002,873.35 | 2,977,819,916.90 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | 3,019,002,873.35 | (41,182,956.45) |
| VI | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,019,002,873.35** | **2,977,819,915.90** |

**СТ-2А**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,427,830,890.14** | **784,387,111.38** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,014,808,690.14 | 65,290,011.38 |

| | | | |
|---|---|---|---|
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,014,808,690.14 | 65,290,011.38 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 4,285,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 4,285,700.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 2,970,835,689.84 | 47,873,492.38 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 43,973,000.30 | 12,890,111.38 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **413,022,200.00** | **719,337,100.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 357,132,300.00 | 623,517,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 357,132,300.00 | 623,517,100.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 55,889,900.00 | 95,820,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 55,889,900.00 | 95,820,000.00 |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **408,828,016.79** | **820,217,859.42** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 408,828,016.79 | 820,217,859.42 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **403,046,930.41** | **786,005,173.56** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **259,119,845.41** | **540,085,973.21** |
| 210101 | Үндсэн цалин | 164,821,164.00 | 343,053,467.56 |
| 210102 | Нэмэгдэл | 90,308,081.41 | 183,835,691.90 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 2,125,000.00 |
| 210104 | Урамшуулал | 3,990,600.00 | 11,071,813.75 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **30,184,195.68** | **67,432,776.92** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,650,063.87 | 45,316,476.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 882,309.56 | 5,279,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 842,005.24 | 2,714,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 408,786.73 | 2,864,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,401,030.28 | 11,258,200.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **30,608,813.62** | **53,607,324.14** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,446,453.62 | 9,717,944.14 |
| 210302 | Түлш, халаалт | 19,285,040.00 | 33,216,120.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,877,320.00 | 10,673,260.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | - |
| 2105 | **Нормативт зардал** | **12,725,350.00** | **31,616,073.90** |
| 210502 | Хоол, хүнс | 12,725,350.00 | 31,616,073.90 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 19,500,000.00 | 7,999,990.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,500,000.00 | 7,999,990.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **871,772.57** | **1,825,364.85** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 871,772.57 | 1,825,364.85 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **50,036,953.13** | **83,437,670.54** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,220,800.00 | 5,402,290.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,711,400.00 | 2,724,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 43,104,753.13 | 75,311,685.86 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,781,086.38 | 34,212,685.86 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **5,781,086.38** | **34,212,685.86** |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,781,086.38 | 34,212,685.86 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **3,019,002,873.35** | **(35,830,748.04)** |
| V | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **3,019,002,873.35** | **(41,182,956.45)** |

**СТ-3А**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **413,022,200.00** | **723,622,800.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 4,,285,700.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 4,285,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 4,285,700.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 413,022,200.00 | 719,337,100.00 |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **357,132,300.00** | **623,517,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 357,132,300.00 | 623,517,100.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **55,889,900.00** | **95,820,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 55,889,900.00 | 95,820,800.00 |
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **370,429,542.40** | **746,398,987.98** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 370,429,542.40 | 746,398,987.98 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **364,648,456.02** | **712,186,973.21** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **260,232,244.15** | **540,085,973.21** |
| 210101 | Үндсэн цалин | 165,933,562.74 | 343,053,467.56 |
| 210102 | Нэмэгдэл | 90,308,081.41 | 183,835,691,90 |
| 210103 | Хоол, унааны хөнгөлөлт | | 2,125,000.00 |
| 210104 | Урамшуулал | 3,990,600.00 | 11,071,813.75 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **30,184,195.68** | **67,432,776.92** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,650,063.87 | 45,316,476.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 882,308.64 | 5,279,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 842,005.24 | 2,714,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 408,786.73 | 2,864,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,401,031.20 | 11,258,200.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **30,608,813.62** | **53,607,324.14** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,446,453.62 | 9,717,944.14 |
| 210302 | Түлш, халаалт | 19,285,040.00 | 33,216,120.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,877,320.00 | 10,673,260.00 |
| 2105 | **Нормативт зардал** | **14,850,330.00** | **30,051,183.00** |
| 210502 | Хоол, хүнс | 14,850,330.00 | 30,051,183.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 19,500,000.00 | 7,999,990.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,500,000.00 | 7,999,990.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **871,772.57** | **1,825,364.85** |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 871,772.57 | 1,825,364.85 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,401,100.00** | **11,183,690.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,346,700.00 | 8,459,490.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,054,400.00 | 2,724,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,781,086.38 | 34,212,685.86 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 5,781,086.38 | 34,212,685.86 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,781,086.38 | 34,212,685.86 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 42,592,657.60 | (22,776,187.98) |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 2,475,000.00 | 2,165,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 2,475,000.00 | 2,165,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 1,765,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 2,475,000.00 | 400,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (2,475,000.00) | (2,165,000.00) |
| 145 | Бусад эх үүсвэр | - | |
| 25 | Санхүүгийн үйл ажиллагааны зардал | | |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 40,117,657.60 | (24,941,187.98) |
| 31 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **40,117,657.60** |
| 31 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **40,117,657.60** | **15,176,469.62** |

**СТ-4А**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** /Төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | **-** | **-** | **3,019,002,873.35** | **3,019,002,873.35** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 3,019,002,873.35 | 3,019,002,873.35 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | **3,019,002,873.35** | **3,019,002,873.35** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (41,182,956.45) | (41,182,956.45) |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | **-** | **-** | **2,9787,819,916.90** | **2,977,819,916.90** |

ТГ

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** /Төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО | 719,500,900.00 | 719,337,100.00 | 163,800.00 | 99.98 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 623,680,900.00 | 623,517,100.00 | 163,800.00 | 99.97 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 623,517,100.00 | 623,517,100.00 | | 100 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 163,800.00 | - | 163,800.00 | |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 163,800.00 | - | 163,800.00 | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 95,820,000.00 | 95,820,000.00 | | 100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 95,820,000.00 | 95,820,000.00 | | 100 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | - | 4,285,700.00 | -4,285,700.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 4,285,700.00 | -4,285,700.00 | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 719,500,900.00 | 723,622,800.00 | -4,121,900.00 | 100.57 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 762,749,000.00 | 746,398,987.98 | 16,350,012.02 | 97.86 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 762,749,000.00 | 712,186,302.12 | 50,562,697.88 | 93.37 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 551,953,200.00 | 540,085,973.21 | 11,867,226.79 | 97.85 |
| 210101 | Үндсэн цалин | 341,040,500.00 | 343,053,467.56 | -2,012,967.56 | 100.59 |
| 210102 | Нэмэгдэл | 200,280,400.00 | 183,835,691.90 | 16,444,708.10 | 91.79 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 2,125,000.00 | -2,125,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 10,632,300.00 | 11,071,813.75 | -439,513.75 | 104.13 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 68,633,900.00 | 67,432,776.92 | 1,201,123.08 | 98.25 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,555,700.00 | 45,316,476.92 | 1,239,223.08 | 97.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,519,500.00 | 5,279,100.00 | 240,400.00 | 95.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,759,800.00 | 2,714,500.00 | 45,300.00 | 98.36 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,759,800.00 | 2,864,500.00 | -104,700.00 | 103.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,039,100.00 | 11,258,200.00 | -219,100.00 | 101.98 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 88,420,000.00 | 53,607,324.14 | 34,812,675.86 | 60.63 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,800,000.00 | 9,717,944.14 | 7,082,055.86 | 57.84 |
| 210302 | Түлш, халаалт | 40,420,000.00 | 33,216,120.00 | 7,203,880.00 | 82.18 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 31,200,000.00 | 10,673,260.00 | 20,526,740.00 | 34.21 |
| 2105 | Нормативт зардал | 30,372,200.00 | 30,051,183.00 | 321,017.00 | 98.94 |
| 210502 | Хоол, хүнс | 30,372,200.00 | 30,051,183.00 | 321,017.00 | 98.94 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,000,000.00 | 7,999,990.00 | 10 | 100 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 7,999,990.00 | 10 | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,021,000.00 | 1,825,364.85 | 195,635.15 | 90.32 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,021,000.00 | 1,825,364.85 | 195,635.15 | 90.32 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,348,700.00 | 11,183,690.00 | 2,165,010.00 | 83.78 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,624,500.00 | 8,459,490.00 | 2,165,010.00 | 79.62 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,724,200.00 | 2,724,200.00 | | 100 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 34,212,685.86 | - 34,212,685.86 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох | - | 34,212,685.86 | - 34,212,685.86 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 34,212,685.86 | - 34,212,685.86 | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 2,165,000.00 | -2,165,000.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | - | 2,165,000.00 | -2,165,000.00 | |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 1,765,000.00 | -1,765,000.00 | |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 400,000.00 | -400,000.00 | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 762,749,000.00 | 748,563,987.98 | 14,185,012.02 | 98.14 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 40,117,657.60 | - 40,117,657.60 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 15,176,469.62 | - 15,176,469.62 | |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | | 100 |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 23 | 20 | | 86.95 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2026 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр төсвийн хуваарь өөрчлөгдөн 2025 оны санхүүгийн тайлангийн төлөвлөгөөнд цалин хөлсний зардал 124,515.9 мянган төгрөгөөр буурч, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 15,204.2 мянган төгрөг буурч,  бараа үйлчилгээний бусад зардал 637.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн өөрчлөлт орсон байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,787.6 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Хангамжийн материалын дансанд 1,336.9 мяган төгрөг давхар орлого авсан, батлагдсан төсвөөс бэлтгэсэн 2,165.0 мянган төгрөгийн хөрөнгийг биет бус хөрөнгө худалдан авах зардалд бүртгээгүй, үр дүнгийн тайланд 4,285.7 мянган төгрөгийг орлогын дансанд нийт 7,787.6 мянган төгрөгийг бүртгээгүй нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" гэсэн заалттай нийцэхгүй байгаа нь “Нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулав

Аудитаар нийт илэрсэн 5,755.5 мянган төгрөгийн зөрчил[2]-д 1,075.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 3,567.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, дахин давтан гаргахгүй 1,112.4 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах 2 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

1. Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн Бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч С.Баярчимэгт 600.0 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” 39 дүгээр тогтоолоор баталсан Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тус цэцэрлэгийн эрхлэгч С.Баярчимэгт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүйгээс нийт 475.2 мянган төгрөг илүү олгож , төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5-д Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно”. 56.2-т “Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно” гэсэн заалттай нийцэхгүй байгаа нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

**5.2 Албан шаардлага**

1. Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В дэх хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2. Тус Цэцэрлэгийн нягтлан бодогч П.Уянга 816.2 мянган төгрөг, нярав Х.Чаминцэцэг 607.7 мянган төгрөг Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн Б/55 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар ”өөрчлөлтгүй” дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 1 дахин нэмэгдүүлж, 1,423.9 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-т "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа нь нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.3 Зөвлөмж**

**<u>5.3.1.1 Илрүүлэлт:Авлагын данстай холбоотой асуудал</u>**

Ажилчдын цалин хөлс, хөдөлмөрийн хөлсний орлогыг нийгмийн даатгалд тайлагнахдаа 1,112.4 мянган төгрөгийг илүү тооцож шилжүүлсэн авлага үүсгэсэн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх"Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; ",Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**5.3.1.2 Өгсөн зөвлөмж:**

Төсвийг зөв зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, авлага үүсгэхгүй ажиллах

Дээрх акт албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[3]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээл лийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Давхар орлого авсан, батлагдсан төсвөөс бэлтгэсэн хөрөнгийг биет бус хөрөнгө худалдан авах зардалд бүртгээгүй, үр дүнгийн тайланд орлогын дансанд бүртгээгүй | 1 | 7,787.6 | | | 1 | 7,787.6 | 1 | 7,787.6 | | | | |
| Дүн | 1 | 7,787.6 | | | 1 | 7,787.6 | 1 | 7,787.6 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

---

.

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуц лага тооцуу лах албан шаардлага | | Хууль, хяналтын байгуулла гад шилжүүл сэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн | То о | Дүн |
| Сургалтын төлбөрийг байгуулла гаар төлүүлсэн | 1 | 600.0 | 1 | 600.0 | | | | | 1 | 600.0 | | |
| хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээ гүй | 1 | 2,144.0 | | | 1 | 2,144.0 | | | | | | |
| Балансын урамшуулал , төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулал тай давхардсан | 1 | 1,423.9 | | | 1 | 1,423.9 | | | | | | |
| Авлага үүсгэсэн | 1 | 1,112.4 | | | | | 1 | 1,112.4 | | | | |
| нэмэгдэл хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүй | 1 | 475.2 | 1 | 475.2 | | | | | 1 | 475.2 | | |
| Дүн | 5 | 5,755.5 | 2 | 1,075.2 | 2 | 3,567.9 | 1 | 1,112.4 | 2 | 1,075.2 | | |

**ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ**

**Байгууллагын нэр: Дархан-уул аймаг Хонгор сумын Салхит баг 32 дугаар цэцэрлэг**

**Аудитын код: ДАА-2026/91/НА-СТА-ТШ3**

**Тайлант хугацаа: 2025 он**

**Эрсдэлтэй АГАДҮТ-н түвшинд хэрэгжүүлэх түүврийн сорилын үр дүнг үнэлж шийдвэрлэх**

| № | Нөлөөлж буй АГАДҮТ | АГАДҮТ-н дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөж өөр тооцох эсэх | Шалгуур: Стандартын заалт | Шалгуур: Хууль тогтоомжийн заалт | Алдаа, зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | Ажил гүйлгээний анги | Цалингийн зардлын данстай холбоотой асуудал | Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсөнд нийт 2,144,000.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй | 2,144,000.00 | Материаллаг | Үгүй | УСНББО УС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга", | Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "*Төсвийн байгууллагын өдөр тутмын* ***үйл ажиллагааг удирдах***", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "*Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,* ***хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна***", 27.6-д "*Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална*", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В дэх хэсэгт "*Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг* ***аль нэг ажилтанд хавсран хариуцуулна***. *Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно*" | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Албан шаардлага | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Ажил гүйлгээний анги | Зардлын данстай холбоотой | Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн Бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч С.Баярчимэгт 600,000.00 төгрөг олгосон | 600,000.00 | Материаллаг | Тийм | УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга", | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39 дүгээр тогтоолоор баталсан Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам" | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Төлбөрийн акт тогтоох | | | |
| 3 | Ажил гүйлгээний анги | Зардлын данстай холбоотой | Тус цэцэрлэгийн эрхлэгч С.Баярчимэгт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүйгээс нийт 475,200.00 төгрөг илүү олгож , төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. | 475,200.00 | Тийм | Тийм | УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга", | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5-д Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно". 56.2-т "Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно" | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Төлбөрийн акт тогтоох | | | |
| 4 | Балансын данстай холбоотой асуудал | Авлагын данстай холбоотой асуудал | Ажилчдын цалин хөлс, хөдөлмөрийн хөлсний орлогыг нийгмийн даатгалд тайлагнахдаа 1,112,398.14 төгрөгийг илүү тооцож шилжүүлсэн авлага үүсгэсэн | 1,112,398.14 | Шинж чанарын хувьд материаллаг | Үгүй | УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга | Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх"Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; ",Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" | Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой | Зөвлөмж өгөх | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Балансын данстай холбоотой асуудал | Зардлын данстай холбоо той асуудал | Тус сургуулийн нягтлан бодогч П.Уянга 1,484,000.00 төгрөг, нярав Х.Чаминцэцэг 1,105,000.00 төгрөг Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, сургуулийн захирлын 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн Б/30 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 1 дахин нэмэгдүүлж, 2,589,000.00 төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна. | 2,589,000.00 | | | | Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-т "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. | Хууль тогтоомжийн хэрэгжилт тэй холбоо той | Албан шаардлага | | | |
| | | | Дүн | 6,920,598.14 | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн түвшинд болон ач холбогдолтой биш эрсдэлүүдэд хэрэгжүүлэх горим, сорилын үр дүнг үнэлж шийдвэрлэх**

| № | Тодорхойлсон эрсдэл | Үр дагавар | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур | | Алдаа, зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Стандартын заалт | Хууль тогтоомжийн заалт | | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн тайлан | Шилэн данстай холбоотой асуудал | Хангамжийн материалын дансанд 1,336,860.00 төгрөг давхар орлого авсан, батлагдсан төсвөөс бэлтгэсэн 2,165,000.00 төгрөгийн хөрөнгийг биет бус хөрөнгө худалдан авах зардалд бүртгээгүй, үр дүнгийн тайланд 4,285,700.00 төгрөгийг орлогын дансанд бүртгээгүй нийт 7,787,560.00 төгрөг байна. | 7,787,560.00 | Тийм | Үгүй | УСНББО УС-2 | НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" | Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой | Санхүүгийн тайланд залруулах | | | |
| **ДҮН** | | | | **7,787,560.00** | | | | | | | | | |
| **НИЙТ ДҮН** | | | | **13,543,108.14** | | | | | | | | | |

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг зөвшөөрсөн:

Дархан-уул аймаг Хонгор сумын Салхит баг 32 дугаар цэцэрлэг эрхлэгч С.Баярчимэг 2026.02.24 Огноо:

Дархан-уул аймаг Хонгор сумын Салхит баг 32 дугаар цэцэрлэг нягтлан бодогч П.Уянга 2026.02.24 Огноо:

Асуудлын бүртгэл хөтөлсөн:

"Шинэчлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-ийн захирал ........................ С.Оргил Огноо:

"Шинэчлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-ийн аудитор ........................ Л.Магсаржалам Огноо:

"Шинэчлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-ийн аудитор ........................ Б.Хоролбат Огноо:

Анхан шатны хяналт хийсэн:

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор ........................ С.Батцэцэг Огноо: 2026.02.24.

Хоёр дахь шатны хяналт хийсэн:

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер ........................ У.Батсүрэн Огноо: 2026.02.24.

Гурав дахь шатны хяналт хийсэн:

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор ........................ Ш.Мөнхбаяр Огноо: 2026.02.24.